



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/140

Улаанбаатар хот

**Худалдан авах ажиллагаа зохион
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төсөв батлах тухай" 2018 оны 02/17 дугаар тогтоол, 2019 оны 23/15 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/424, А/462 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/424 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дүгээр ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/62 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо, 2 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/43 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо, 4 дүгээр ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/47 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо, 6, 7 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо, 8, 9, 10, 11, 13, 14, 15 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/44 тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо, 12 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо,

Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/462 дугаар захирамжийн хавсралтад заасан 1, 2 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/25 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороонд тус тус даалгасугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг нийслэлийн Авто замын хөгжлийн газар, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр, Т.Хэрлэн/-дод үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

